SBG SWISSBETTERGOLD

Эх үүсвэрийн стратеги

2025 оны 6-р сар



Агуулга

1. **ТАНИЛЦУУЛГА** **2**
2. **ХАМРАХ ХҮРЭЭ БОЛОН ХЭРЭГЛЭЭ** **3**
3. **ТАСРАЛТГҮЙ САЙЖРУУЛАЛТ БА ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН УРАМШУУЛАЛ** **4**
4. **SBG-ИЙН АХИЦ ДЭВШЛИЙН ШАЛГУУР** **5**
5. **ХЯНАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ** **10**
6. **ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭГДЭЛ** **11**
7. **ҮЛ НИЙЦЭЛ** **12**

1. ТАНИЛЦУУЛГА

Швейцарын Хариуцлагатай алтны холбоо (Swiss Better Gold Association) нь Швейцарын Эдийн засгийн асуудал эрхэлсэн Төрийн Нарийн бичгийн дарга нарын газар (SECO)-ын дэмжлэгтэйгээр алт цэвэршүүлэгчээс жижиглэн худалдаачид хүртэлх алтны нийлүүлэлтийн сүлжээнд идэвхтэй оролцогч Швейцарын бизнес эрхлэгчдийн үүсгэн байгуулсан ашгийн бус холбоо юм. Энэ нь сонирхож буй, хариуцлагатай гишүүдэд нээлттэй санаачилга юм. SBG Холбооны зорилго нь зах зээлд суурилсан механизмыг бүрдүүлэх замаар хүлээн зөвшөөрөгдсөн, хариуцлагатай бичил, жижиг, дунд оврын алт үйлдвэрлэгчдийг нийгэмд хүртээмжтэй, аюулгүй, цэвэр, байгаль орчинд хал багатай үйл ажиллагааны арга туршлагыг нэвтрүүлж, тогтвортой хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхэд оршино.

2013 онд SBG Холбоо нь SECO-той хамтран SBG Хөтөлбөр (SBG Санаачилга) хэрэгжүүлж эхэлсэн. Түүнээс хойш энэхүү хөтөлбөр нь төр-хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжиж байна. Энэхүү түншлэлийн зорилго нь хөтөлбөрийн дэмжлэг авсан хариуцлагатай бичил үүрхайчдын олон улсын алтны зах зээлд нийлүүлэх алтны хэмжээг ихээр нэмэгдүүлэх замаар орон нутаг дахь нөлөөллийг мэдэгдэхүйц өсгөхөд оршино. Энэ зорилтод хүрэхийн тулд Холбоо нь энэхүү баримт бичигт тусгасан эх үүсвэрийн стратегийг боловсруулсан болно.

SBG-ийн хариуцлагатай эх үүсвэрээс алт нийлүүлэх стратеги буюу эх үүсвэрийн стратеги нь SBG-ийн ерөнхий хандлага, зарчмыг тодорхойлох гол баримт бичиг юм. Энэхүү стратеги нь нийлүүлэлтийн сүлжээний онцлог хэлбэрүүдийг харгалзан үзэж, алт угаагчдад, мөн баяжуулах үйлдвэрүүдтэй хамтран ажиллахад зориулсан тусгай загварууудыг багтаана. Эдгээр загварууд нь бүтцийн хувьд энэхүү баримт бичигт тодорхойлсон үндсэн хандлага, зарчмуудыг ямагт тусгасан байдаг. Эдгээр тусгай загварууудыг хавсралтаас үзнэ үү.

SBG-ийн эх үүсвэрийн стратеги нь SBG-ийн үйл ажиллагаа явагдаж буй орнуудын газар дээрх нөхцөл байдал өөрчлөгдөх, түүнчлэн үйл ажиллагааны явцад хуримтлуулсан мэдлэг, туршлагад нийцүүлэн үян хатан байдлаар өөрчлөн тохируулах боломжтой байхаар боловсруулагдсан. Иймээс SBG Холбоо нь гишүүд болон гол оролцогч талууд,

тухайлбал SBG-ийн нийлүүлэлтийн сүлжээний тоглогчидтой зөвлөлдөн уг стратегийг байнга

© Swiss Better Gold 2025

шинэчилж байдаг.

SBG Холбоо нь энэхүү эх үүсвэрийн стратегийг алт үйлдвэрлэгчдийн төрөл бүрийн сүлжээнд хэрэгжүүлж болохуйц дагалдах техникийн зааварчилгаа, лавлах баримт бичиг, протокол, журмуудыг боловсруулан гаргасан. Түүнчлэн эдгээр нь SBG-ийн хараат бус баталгаажуулагчдад үйлдвэрлэгчдийн магадлан итгэмжлэлийн статусыг дахин баталгаажуулахад нь баримтлах арга хэрэгсэл болох юм.

2. ХАМРАХ ХҮРЭЭ БОЛОН ХЭРЭГЛЭЭ

SBG-ийн эх үүсвэрийн стратеги бол SBG-ийн зүгээс үүл уурхайн үйлдвэрлэгчдийн хариуцлагатайгаар олборлосон алтыг зах зээлд нийлүүлэхэд дэмжин хамтран ажиллаж буй бүхий л улс орнуудад хамааралтай.

SBG-ийн эх үүсвэрийн стратеги нь бичил уурхайчдаас дунд оврын олборлогчид хүртэл багтсан үүл уурхайн үйлдвэрлэгчдийн өргөн хүрээг хамарна. Бичил уурхайчид[1] нь хоршоо, жижиг аж ахуйн нэгж, эсвэл гэр бүлийн бизнесийн хэлбэрээр зохион байгуулагдсан байж болно. Тус стратеги нь дунд болон том хэмжээний үүл уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай дээр эсвэл түүний ойролцоо ажиллаж буй бичил уурхайчдад мөн хамаарна. Энэ тохиолдолд SBG нь эдгээр бичил уурхайчдыг оролцуулсан нийлүүлэлтийн сүлжээ бий болгохын тулд дунд болон том хэмжээний олборлогчидтой хамтран ажиллаж болно. Эцэст нь, SBG-ийн оролцоо нь байгаль орчин, нийгэм болон засаглалын хувьд нэмэлт үр нөлөө бий болгох боломжтой гэж үзсэн тохиолдолд тус байгууллага дунд хэмжээний үйлдвэрлэгчидтэй мөн хамтран ажилладаг.

Хэрэв үүл уурхайн үйлдвэрлэгч нь тухайлсан Сайн дурын тогтвортой байдлын стандарт **(**Voluntary Sustainability Standard VSS**)**-ын гэрчилгээ[2] авах зорилготой бол SBG нь шаталсан сайжруулалтын аргачлалаа **(**эскалаторын аргачлал**)** зэрэгцүүлэн хэрэгжүүлдэг.


[1] SBG Холбоо нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) Зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэлтэй нутаг дэвсгэрээс гаралтай эрдэс баялгийн хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээний магадлан шинжилгээний удирдамжийн гурав дахь хэвлэлийн 65-р хуудсанд заасан Бичил уурхайн тодорхойлолтыг баримталдаг. “Бичил уурхай гэж ихэвчлэн хайгуул, олборлолт, боловсруулалт болон тээвэрлэлтийн хялбаршуулсан хэлбэр бүхий албан ба албан бус олборлох үйл ажиллагааг хэлнэ. Бичил уурхай нь ерөнхийдөө хөрөнгө оруулалт багатай, хөдөлмөр их шаарддаг технологи ашигладаг. Бичил уурхай гэдэгт хувиараа ажиллаж байгаа эрэгтэй эмэгтэй хувь хүмүүс, мөн гэр бүлээрээ, түншлэл хэлбэрээр ажиллаж буй хүмүүс, хоршоо нөхөрлөл, бусад хууль ёсны нэгдэл болон олон зуу, мянган уурхайчдаас бүрдсэн байгууллага зэргийг хамруулж үзэж болно. Тухайлбал, олборлолтын нэг цэг дээр хамтын хүчээ нэгтгэж (нэг цооног ухах зэргээр) 4-10 хүнтэй бүлгээр, заримдаа гэр бүлээрээ ажиллах нь түгээмэл байдаг. Зохион байгуулалтын түвшинд гэвэл 30-300 хүнтэй бүлэг нэг орд дээр хамтран олборлох (өөр өөр цооног дээр ажиллах г.м) нь элбэг, зарим тохиолдолд боловсруулах технологио хуваалцдаг”. (https://www.oecd.org/daf/inv/mne/OECD-Due-Diligence-Guidance-Minerals-Edition3.pdf)

[2] Тухайлбал**:** Шударга олборлолт, Шударга худалдаа, Хариуцлагатай үнэт эдлэлийн зөвлөл, Хариуцлагатай эрдэс баялгийн санаачилга гэх мэт.

Энэхүү баримт бичиг нь Швейцарын Хариуцлагатай алтны холбооны (Swiss Better Gold Association-SBG) өмч бөгөөд эрх эзэмшигчээс бичгээр тусгайлан зөвшөөрөл олгоогүй тохиолдолд аливаа хэлбэрээр хуулбарлах, задруулах, ашиглахыг хориглоно.
© Swiss Better Gold 2025
Дэлгэрэнгүй мэдээллийг: info@sbga.ch

3. ТАСРАЛТГҮЙ САЙЖРУУЛАЛТ БА ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН УРАМШУУЛАЛ

SBG нь алтны бичил уурхай болон бага оврын уурхайн үйл ажиллагаанд төвлөрч, хариуцлагатай үул уурхайн олборлолтоос зах зээл хүртэлх алтны нийлүүлэлтийн урсгалыг дэмжин ажилладаг. Тасралтгүй сайжруулалт бол SBG-ийн эх үүсвэрийн стратегийг амжилттай хэрэгжүүлэх гол зарчим, үндсэн суурь нь юм. Оролцогч үул уурхайн үйлдвэрлэгчдийг үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулахад нь урамшуулан дэмждэг бөгөөд SBG-ийн шалгууруудыг хангаж байгаагаа нотлон харуулах замаар олон улсын алтны зах зээлд үе шаттайгаар нэвтрэх боломжийг олгодог. Энэхүү ахиц дэвшлийн аргачлалыг SBG-ийн Тасралтгүй сайжруулалтын шаталсан аргачлал (SBG Continuous Improvement Escalator) буюу товчоор SBG Эскалатор аргачлал гэж нэрлэдэг. Уг аргачлалыг Зураг 1-д үзүүлэв.



Зураг 1: SBG Тасралтгүй сайжруулалтын шаталсан аргачлал болон урамшуулал

SBG-ийн Тасралтгүй сайжруулалтын шаталсан аргачлал (Эскалатор аргачлал) нь дараах гурван ахиулсан үе шаттай**:** Боломжит үйлдвэрлэгчдийг анхан шатны сонгон шалгаруулалтаар сонгох; SBG-ийн баталгаажсан нийлүүлэгч болох; эцэст нь гүйцэтгэлийг тасралтгүй хянаж, тайлагнах замаар статусаа хадгалах.

Энэхүү баримт бичиг нь Швейцарын Хариуцлагатай алтны холбооны (Swiss Better Gold Association-SBG) өмч бөгөөд эрх эзэмшигчээс бичгээр тусгайлан зөвшөөрөл олгоогүй тохиолдолд аливаа хэлбэрээр хуулбарлах, задруулах, ашиглахыг хориглоно.
© Swiss Better Gold 2025
Дэлгэрэнгүй мэдээллийг: info@sbga.ch

Уул уурхайн үйлдвэрлэгчид, ялангуяа жижиг, эмзэг үйлдвэрлэгчдийг SBG-ийн шаталсан аргачлалаар өгсөж, илүү өндөр стандарт хэрэгжүүлэх, байгууллагын чадавхыг сайжруулах, түүнчлэн илүү бүтээмжтэй, үр ашигтай, аюулгүй, цэвэр аргаар олборлолт хийхийг сэдэлжүүлэх зорилгоор SBG нь дараах урамшууллыг олгодог. Үүнд:

- **SBG Холбооны гишүүдийн зах зээл болон нийлүүлэлтийн сүлжээнд нэвтрэх боломж:** Олон үйлдвэрлэгчийн хувьд SBG Холбооны гишүүдийн нийлүүлэлтийн сүлжээнд нэвтрэх нь ихээхэн давуу талыг олгодог. Холбооны гишүүд нь урт хугацааны гэрээний баталгаа, ихэнх улс орны дотоодын зах зээлээс ихэвчлэн тогтвортой өндөр үнэ, эрэлтийн баталгаа, мөн зээлийн маш бага эрсдэл зэрэг орон нутгийн худалдаачидтай харьцуулахад үйлдвэрлэгчдэд илүү таатай худалдааны нөхцөл санал болгодог.
- **SBG-ийн чадавх хөгжүүлэх үйл ажиллагаа болон техникийн туслалцаа:** SBG-ийн хэрэгжүүлэгч түншүүд нь уул уурхайн үйлдвэрлэгчдийн чадавхыг хөгжүүлэх, мэргэжлийн туслалцаа үзүүлэх чиглэлээр орон нутагт ажилладаг. Хэрэгжүүлэгч түншүүд нь хариуцлагатай уул уурхайн бүхий л чиглэлийн мэргэжилтнүүдтэй хамтран SBG-ийн Тасралтгүй сайжруулалтын шаталсан аргачлалын дагуу дараагийн түвшинд хүрэх боломжтой мөн хүсэл эрмэлзэлтэй үйлдвэрлэгчдийг дэмжиж ажилладаг. Үйлдвэрлэгчдэд үзүүлэх дэмжлэгийн түвшин нь тухайн уурхайн хэрэгцээ шаардлага болон боломжит санхүүжилтийн хэмжээнээс хамаарна.
- **Орон нутгийн хөгжил:** SBG Холбоо нь шаардлага хангасан уул уурхайн үйлдвэрлэгчдэд тэдэнтэй шууд холбоотой орон нутгийн эдийн засаг, байгаль орчин, нийгмийн хөгжлийг дэмжих төслүүдэд зориулан хамтарсан санхүүжилт олгодог. Төслийн зорилго болон санхүүжилтийг хэрхэн ашиглах талаар SBG Холбоо болон үйлдвэрлэгч гэрээ байгуулан харилцан тохиролцож, SBG-ийн хэрэгжүүлэгч түншүүдийн дэмжлэгтэйгээр зохион байгуулдаг.

4. SBG-ИЙН АХИЦ ДЭВШЛИЙН ШАЛГУУР

SBG-ийн хэрэгжүүлэгч түншүүд нь SBG хөтөлбөрт оролцох боломжтой, хүсэл эрмэлзэлтэй уул уурхайн үйлдвэрлэгчдийг тодорхойлдог[3]. Бичил уурхайн хувьд SBG нь зөвхөн, Лондоны Үнэт металлын холбооны (LBMA) Хариуцлагатай алтны удирдамж болон ЭЗХАХБ-ын Зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэлтэй нутаг дэвсгэрээс гаралтай эрдэс баялгийн хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээний магадлан шинжилгээний удирдамжид тодорхойлсон “хууль ёсны” бичил уурхайчидтай хамтран ажилладаг.[4] Ерөнхийдөө SBG хөтөлбөрт оролцож буй уул уурхайн үйлдвэрлэгчид бүрэн албажсан байх, эсвэл албажих үйл явцдаа дорвитой ахиц гаргасан байх шаардлагатай.

[3] Швейцарын Хариуцлагатай алтны холбооны (Swiss Better Gold Association) бүх гишүүд нь Швейцар болон үйл ажиллагаа явуулж буй бусад улс орнуудын “алтны эх үүсвэр”-тэй холбоотой холбогдох хууль тогтоомж, зохицуулалтыг мэдэж, дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд үүнд боломжит, шинэ болон одоо хамтран ажиллаж буй нийлүүлэгчид, бизнесийн түншүүд, харилцагчдад мөнгө угаахтай тэмцэх болон бусад зохих магадлан шинжилгээ хийхтэй холбоотой үүрэг хариуцлага багтана.

[4] Лондоны Үнэт металлын холбооны (LBMA) Хариуцлагатай алтны удирдамж: (https://www.lbma.org.uk/responsible-sourcing); ЭЗХАХБ-ын Зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэлтэй нутаг дэвсгэрээс гаралтай эрдэс баялгийн хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээний магадлан шинжилгээний удирдамж (https://www.oecd.org/daf/inv/mne/OECD-Due-Diligence-Guidance-Minerals-Edition3.pdf) үзнэ үү.

Энэхүү баримт бичиг нь Швейцарын Хариуцлагатай алтны холбооны (Swiss Better Gold Association-SBG) өмч бөгөөд эрх эзэмшигчээс бичгээр тусгайлан зөвшөөрөл олгоогүй тохиолдолд аливаа хэлбэрээр хуулбарлах, задруулах, ашиглахыг хориглоно.
© Swiss Better Gold 2025
Дэлгэрэнгүй мэдээллийг: info@sbga.ch

Уул үүрхайн үйлдвэрлэгчид нь SBG-ийн Тасралтгүй сайжруулалтын шаталсан аргачлалын дараагийн түвшинд дэвшиж, 3-р хэсэгт дурдсан урамшууллуудаас хүртэхийн тулд хөтөлбөрөөс тасралтгүй дэмжлэг авч, үе шат бүрт хамаарах SBG-ийн эх үүсвэрийн шалгуурыг хангаснаа харуулах боломжтой болно.

Эдгээр шалгуурыг хариуцлагатайгаар олборлосон (бичил уурхайн) алт худалдан авах хүсэлтэй брэндүүд болон үйлдвэрлэгчдийн чухал бөгөөд зайлшгүй хүлээлтийг хангах зорилгоор боловсруулсан бөгөөд алт ашигладаг үйлдвэрлэлийн онцлог, салбар дамнасан нийцлийн шаардлагуудыг мөн хамарна. SBG-ийн эх үүсвэрийн шалгуур үзүүлэлтүүдийг бичил уурхайн алтны хариуцлагатай үйлдвэрлэл, нийлүүлэлтэд хамаарах олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудад үндэслэж нийцүүлсэн болно. Үүнд, Лондоны Үнэт металлын холбооны Хариуцлагатай алтны удирдамж, ЭЗХАХБ-ын Зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэлтэй нутаг дэвсгэрээс гаралтай эрдэс баялгийн хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээний магадлан шинжилгээний удирдамж, Дэлхийн Алтны зөвлөлийн Хариуцлагатай алт олборлолтын зарчмууд[5] зэрэг стандартууд багтдаг. SBG-ийн баталгаажуулалтын удирдамж нь эдгээр эх үүсвэрийн шалгуурын хүрээнд засаглал, нийгэм, байгаль орчны гол эрсдэлүүдийг шийдвэрлэхэд чиглэсэн эрсдэлийн удирдлагын үйл явц болон үйл ажиллагаанд тавигдах шаардлагуудыг тодорхойлсон байдаг.

SBG нь нийт 27 шалгуур үзүүлэлттэй бөгөөд эдгээр нь байгаль орчин, нийгэм, засаглалын 3 үндсэн хэсэгт хуваагддаг. Эдгээр шалгуурын 10-ыг нь SBG-ийн шаталсан аргачлалын 1-р шатанд заавал хангах ёстой бөгөөд эдгээрийг "суурь" шалгуур гэдэг. Үлдсэн 17 шалгуурыг SBG-ийн шаталсан аргачлалын 2-р шатанд хангах бөгөөд эдгээрийг SBG-ийн шалгуур гэнэ. Дараах хэсэгт SBG-ийн шаталсан аргачлалын гурван шат түс бүрт хамаарах шалгуурууд, мөн уул уурхайн үйлдвэрлэгчдийг дараагийн шатанд ахихад нь SBG-ийн хэрэгжүүлэгч түншүүдээс үзүүлэх дэмжлэг, туслалцааг дэлгэрэнгүй тайлбарласан болно.

1-р ШАТ: 1-р шатанд үйлдвэрлэгчдийг SBG-ийн хэрэгжүүлэгч түншүүд үнэлж, 10 суурь шалгуурыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулна. Эдгээр шалгуурын сүүлийнх нь үйлдвэрлэгч бүтэц бүхий тасралтгүй сайжруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрсөн, мөн уг төлөвлөгөөнд тусгасан хугацаатай арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хамарна. Тасралтгүй сайжруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэгч түнштэй хамтран боловсруулах бөгөөд энэ нь SBG хөтөлбөрт үйлдвэрлэгчийн үүрэг амлалт, мөн SBG-ийн эх үүсвэрийн шалгуурыг хангах хүчин чармайлтыг нотлох зорилготой.

1-р шатанд уул уурхайн үйлдвэрлэгчдийг урамшуулахын тулд SBG-ийн хэрэгжүүлэгч түншүүд нь тухайн үйлдвэрлэгчийн тасралтгүй сайжруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулахад нь техникийн туслалцаа үзүүлдэг.

[5] Эх сурвалж: Лондоны Үнэт металлын холбооны (LBMA) Хариуцлагатай эх үүсвэрийн хөтөлбөр (https://www.lbma.org.uk/responsible-sourcing), ЭЗХХАБ-ын (OECD) Зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэлтэй нутаг дэвсгэрээс гаралтай эрдэс баялгийн хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээний магадлан шинжилгээний удирдамж (https://www.oecd.org/daf/inv/mne/OECD-Due-Diligence-Guidance-Minerals-Edition3.pdf), Дэлхийн Алтны Зөвлөлийн Хариуцлагатай алт олборлолтын зарчмууд (https://www.gold.org/about-gold/gold-supply/responsiblegold/responsible-gold-mining-principles)

.

Энэхүү баримт бичиг нь Швейцарын Хариуцлагатай алтны холбооны (Swiss Better Gold Association-SBG) өмч бөгөөд эрх эзэмшигчээс бичгээр тусгайлан зөвшөөрөл олгоогүй тохиолдолд аливаа хэлбэрээр хуулбарлах, задруулах, ашиглахыг хориглоно.
© Swiss Better Gold 2025

SBG Холбооны гишүүд нь 1-р шатанд байгаа үүл үүрхайн үйлдвэрлэгчидтэй хамтран ажиллаж**,** SBG-ийн эх үүсвэрийн "суурь" шалгуурыг хангаж**,** уурхай нь хууль ёсны бөгөөд 2-р шатанд ахих зорилгоор тасралтгүй сайжруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх албан ёсны үүрэг амлалт авсан тохиолдолд тэднээс алт худалдан авдаг. Үйлдвэрлэгчид нь SBG-ийн эх үүсвэрийн хөтөлбөрт хамрагдсан өдрөөс эхлэн 24 сарын дотор шаардлагатай шалгууруудыг хангаж, SBG-ийн шаталсан аргачлалын 2-р шатанд шилжин орох үүрэгтэй.

1-р шат Суурь шалгуур		
Хүрээ	**Шалгуур**	**Тодорхойлолт**
Засаглал болон байгууллагын чадавх	Хууль ёсны байдал	Үйлдвэрлэгчид нь хууль ёсны[6] бичил уурхайчид байна.
	Алтны гарал үүслийг нотлох[7]	Үйлдвэрлэгчид нь хууль ёсны дагуух үйл ажиллагаагаа (гарал үүсэл, боловсруулалт болон худалдаа/экспортын үйл явц) мөшгөх боломжийг хангах тогтолцоо эсвэл бүртгэлтэй байна.
	Үүл уурхайн байгууллагууд	Үйлдвэрлэгчид нь хууль есны үүл уурхайн аж ахуйн нэгжүүд[8] байна.
	Зэвсэгт мөргөлдөөн	Үйлдвэрлэгчид төрийн бус зэвсэгт бүлэглэлүүдийг шууд болон шууд бусаар дэмжихгүй.
	Тасралтгүй сайжруулалтын төлөвлөгөө	Үйлдвэрлэгчид SBG-ийн шалгуурыг хангах зорилгоор хэмжиж болохуйц, тодорхой хугацаатай тасралтгүй сайжруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.
Нийгэм	Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг хориглох	Үйлдвэрлэгчид хүүхдийн тэвчишгүй хөдөлмөртэй[9] ямар нэг хэлбэрээр холбогдохгүй.
	Албадан хөдөлмөр эрхлүүлэхгүй байх	Үйл ажиллагаанд хүчээр буюу албадан хөдөлмөр эрхлүүлэхгүй.
	Хүний эрх	Үйлдвэрлэгчид эрүүдэн шүүх, харгис, хүнлэг бус болон доромжилсон харьцааны аливаа хэлбэр, хүний эрхийн ноцтой зөрчил, дайны гэмт хэрэг, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн бусад ноцтой зөрчил, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, эсхүл геноцидтой ямар нэгэн байдлаар холбоогүй байна.

[6] Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) "Зөрчил мөргөлдөөн, болон өндөр эрсдэлтэй бүс нутгаас гаралтай эрдэс баялгийн хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээний магадлан шинжилгээний удирдамж"-ийн 69-р хуудас дахь тодорхойлолтын дагуу: "Хууль ёсны бичил уурхай: Нөхцөл байдалтай холбоотой олон хүчин зүйлс (Хавсралтыг үз)-ийг авч үздэг тул бичил уурхайн хууль ёсны байдлыг тодорхойлоход төвөгтэй байдаг. Энэхүү Удирдамжийн хувьд хууль ёсны байдал гэдэг нь холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн үйл ажиллагаа явуулж буй бичил уурхайг хэлнэ. Холбогдох хууль эрхзүйн тогтолцоог дагаж мөрдөөгүй, эсвэл энэ төрлийн тогтолцоо байхгүй бол бичил уурхайн хууль ёсны байдлыг үнэлэхдээ (хүчин төгөлдөр мөрдөгдөж буй) хууль эрхзүйн холбогдох орчинд уурхайчид, байгууллагууд ажиллах гэж хичээл зүтгэл гаргаж буй байдал, мөн аль болох албан ёсны болох боломжуудад хамрагдах гэж оролдож буй байдал зэргийг харгалзан үзнэ (ихэнх тохиолдолд бичил уурхайчид нь чадавх, техникийн боломж, санхүүгийн нөөцгүй, эсвэл хязгаарлагдмал байдгийг анхаарч үзнэ). Аль ч тохиолдолд бичил уурхай нь Удирдамжийн 2-р хавсралтад тодорхойлсон эрдэс баялгийн олборлолт, тээвэрлэлт, худалдаа зэрэгтэй холбоотой ноцтой зөрчил, мөргөлдөөнд оролцож байгаа тохиолдолд хууль ёсны гэж үзэхгүй. (https://www.oecd.org/daf/inv/mne/OECD-Due-Diligence-Guidance-Minerals-Edition3.pdf).

[7] 2024 оны 5 дугаар сараас эхлэн мөрдөнө.

[8] Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) тодорхойлолтын (65-р хуудас) дагуу: "Бичил уурхайн байгууллага гэж энэхүү Удирдамжийг хэрэгжүүлэхээр хангалттай хэмжээний бүтэц зохион байгуулалтад орж, албажсан бичил уурхайн байгууллагууд. Хавсралтад заасанчлан бүх бичил уурхайчид энэ маягаар албажихыг уриалж байна". (https://www.oecd.org/daf/inv/mne/OECD-Due-Diligence-Guidance-Minerals-Edition3.pdf).

[9] Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ILO)182 дугаар Конвенцыг үзнэ үү. (https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:12100:0::NO::P12100_ILO_CODE:C182)

Энэхүү баримт бичиг нь Швейцарын Хариуцлагатай алтны холбооны (Swiss Better Gold Association-SBG) өмч бөгөөд эрх эзэмшигчээс бичгээр тусгайлан зөвшөөрөл олгоогүй тохиолдолд аливаа хэлбэрээр хуулбарлах, задруулах, ашиглахыг хориглоно.
© Swiss Better Gold 2025
Дэлгэрэнгүй мэдээллийг: info@sbga.ch

Байгаль орчин	Экологийн өндөр ач холбогдолтой газрууд	ЮНЕСКО-гийн Дэлхийн байгалийн өвийн газар[10], Биологийн олон янз байдлын чухал бүсүүд[11], Устаж үгүй болохоос сэргийлэх эвслийн хамгаалалтын газрууд[12], мөн Байгаль хамгаалах олон улсын холбооны I–IV ангиллын хамгаалалттай газар нутаг[13] зэрэг экологийн өндөр ач холбогдол бүхий бүс нутагт үүл үүрхайн үйл ажиллагаа явуулахгүй байх.
	Мөнгөн усыг хамгийн хортой хэлбэрээр ашиглахгүй байх	Үйлдвэрлэгчид алт бариулах явцдаа мөнгөн усыг хамгийн аюултай хэлбэрээр ашиглахгүй.

2-р ШАТ: Уул үүрхайн үйлдвэрлэгч SBG-ийн бүх 27 шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан үед 2-р шатыг дүүргэсэнд тооцогдоно. Энэ шатанд үйлдвэрлэгч нь SBG Холбоотой харилцан тохиролцсон (орон нутгийн) хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх хамтарсан санхүүжилт авах эрхтэй болно. Үйлдвэрлэгч нь SBG-ийн магадлан итгэмжлэгдсэн үйлдвэрлэгч статустай болсны дараа эдгээр санхүүжилтийн шаардлагыг хангана.

2-р шат SBG-ийн шалгуур		
Хүрээ	**Шалгуур**	**Тодорхойлолт**
Засаглал болон байгууллагын чадавх	Үндэсний хууль тогтоомжийг мөрдөж ажиллах	Үйлдвэрлэгчид үндэсний хэмжээний бүх хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.
	Мөшгөлтийн тогтолцоог хэрэгжүүлэх[14]	Үйлдвэрлэгчид эрдэс баялгийг олборлох цэгээс баяжуулалт, худалдаа болон экспорт хүртэлх нийлүүлэлтийн сүлжээний бүх үе шатанд мөшгөлтийн тогтолцоог хэрэгжүүлсэн байна.
	Байгууллагын бүтэц, зохион байгуулалт	Үйлдвэрлэгчид өөрийн хэмжээнд тохирсон тодорхой, ил тод бүтэц болон шийдвэр гаргах тогтолцоотой байх бөгөөд энэ нь SBG-ийн эх үүсвэрийн шалгуурыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг баримтжуулах, үр дүнтэй хяналт шинжилгээ хийх боломжийг бүрдүүлнэ.

[10] "Дэлхийн өвийн газар" гэж Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн газар, өмчийг хэлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн жагсаалт-аас үзнэ үү. (http://whc.unesco.org/en/list/

[11] "Биологийн олон янз байдлын гол бүс нутгууд" гэдэг нь дэлхий нийтээр стандартчилсан шалгуурыг ашиглан биологийн олон янз байдлыг хамгаалах олон улсын ач холбогдол бүхий газруудыг тодорхойлж, тогтоох аргачлал юм. Нэмэлт тодорхойлолтыг "Биологийн олон янзын байдлын гол бүс нутгийн дэлхийн мэдээллийн сан", "Биологийн олон янзын байдлын гол бүс нутгийг тодорхойлох дэлхийн стандарт"-аас үзнэ үү.

[12] Устаж, үгүй болохоос сэргийлэх Эвсэл (Alliance for Zero Extinction AZE) нь төрөл зүйл устаж, үгүй болохоос сэргийлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлээр ажилладаг 88 төрийн бус байгууллагын эвсэл юм. AZE-ийн үнэлгээгээр 587 газар нутаг болон 920 зүйл нь "устах аюулд орсон" (Endangered) эсвэл "нэн ховордсон" (Critically Endangered) ангилалд хамаарч байна. Эдгээрийн байршлын зураг болон жагсаалтыг AZE-ийн цахим хуудаснаас үзэх боломжтой. (https://zeroextinction.org/)

[13] Байгаль хамгаалах олон улсын Холбооны (International Union for Conversation of Nature IUCN) хамгаалалттай газар нутгийн менежментийн ангиллууд нь хамгаалалттай газар нутгийг менежментийн зорилгоор нь ангилдаг бөгөөд эдгээрийг НҮБ зэрэг олон улсын байгууллагууд хүлээн зөвшөөрдөг. Ангиллын мэдээллийг дараах вебсайтаас авна уу. (https://www.iucn.org/theme/protected-areas/about/protected-areas-categories).

[14] 2024 оны 5 дугаар сараас эхлэн мөрдөнө.

	Авлига, хээл хахуулиас ангид байх	Үйлдвэрлэгчид авлига, хээл хахуулийг хориглосон авлигын эсрэг бодлого хэрэгжүүлнэ.
	Зөрчилдөөний магадлан шинжилгээ	Үйлдвэрлэгчид ЭЗХАХБ-ын “Зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэлтэй нутаг дэвсгэрээс гаралтай эрдэс баялгийн хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээний магадлан шинжилгээний удирдамж”, түүний дотор Хавсралт II-д тусгагдсан Нийлүүлэлтийн сүлжээний загвар бодлоготой нийцсэн эрсдэлийн удирдлагын аргачлалыг хэрэгжүүлсэн байна.
Нийгэм	Хүүхдийн хөдөлмөр ашиглахгүй байх	Үйл ажиллагаанд 15-аас доош насны хүүхэд ажиллуулахгүй бөгөөд 18-аас доош насны хүүхдээр аюултай ажил гүйцэтгүүлэхгүй.
	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	Ажилчид доод тал нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжина.
	Эвлэлдэн нэгдэх эрх	Үйлдвэрлэгчид бүх ажилтны эвлэлдэн нэгдэх, ажилчдын байгууллагад элсэх, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, болзлын талаар хамтын хэлэлцээ хийх эрхийг хүлээн зөвшөөрнө.
	Аюулгүй ажиллагаа	Үйлдвэрлэгчид аюулгүй ажиллах орчин бүрдүүлнэ.
	Жендэрийн эрх тэгш байдал	Үйлдвэрлэгчид жендэрийн эрх тэгш бус байдлыг илрүүлж, шийдвэрлэх үүрэг амлалтаа тодорхой харуулна.
	Аюулгүй байдлын хамгаалалт, хүний эрх	Хамгаалалтын ажилтан, хамгаалалтын үйлчилгээ авдаг үйлдвэрлэгчид үйл ажиллагаагаа “Аюулгүй байдлын хамгаалалт ба хүний эрхийн сайн дүрын зарчмууд”-д нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлнэ.
	Олон нийтийн харилцаа	Үйлдвэрлэгчид өөрсдийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдтэй эерэг, харилцан ашигтай, амар тайван харилцаа тогтооход тодорхой үүрэг хүлээж буйгаа харуулж, гомдол, саналыг зохистойгоор шийдвэрлэх механизмыг бүрдүүлнэ.
Байгаль орчин	Хог хаягдлын менежмент	Үйлдвэрлэгчид байгаль орчин, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд олборлолт, баяжуулалтын болон бусад хог хаягдлын менежментийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.
	Баяжуулалтын хаягдлын менежмент	Үйлдвэрлэгчид баяжуулалтын хаягдал болон түүнтэй холбоотой бохир усыг зайлуулах ажлыг зохистой төлөвлөж, тэдгээрийг бусад усны эх үүсвэрт нийлүүлэхээс үр дүнтэйгээр сэргийлнэ
	Мөнгөн усны менежмент	Үйлдвэрлэгчид Минаматагийн конвенцын хавсралт С-д заасан мөнгөн усыг халах арга хэмжээнүүдтэй нийцсэн үүрэг амлалтаа нотлон харуулна.

Энэхүү баримт бичиг нь Швейцарын Хариуцлагатай алтны холбооны (Swiss Better Gold Association-SBG) өмч бөгөөд эрх эзэмшигчээс бичгээр тусгайлан зөвшөөрөл олгоогүй тохиолдолд аливаа хэлбэрээр хуулбарлах, задруулах, ашиглахыг хориглоно.
© Swiss Better Gold 2025
Дэлгэрэнгүй мэдээллийг: info@sbga.ch

	Цианидын менежмент	Үйлдвэрлэгчдийн цианидаар үүсган баяжуулах үйлдвэрүүд нь байгаль орчны бохирдлоос үр дүнтэй сэргийлсэн байдлаар баригдсан байх бөгөөд зохих сургалтад хамрагдсан насанд хүрсэн хүнийг ажиллуулна.
	Уур амьсгалын өөрчлөлт[15]	Үйлдвэрлэгчид хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээг тодорхойлох, баримтжуулах (тайлагнах), хэрэгжүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үүрэг хариуцлагаа нотлон харуулна. Мөн усны нөөцийг үр ашигтай удирдах, усны бохирдол болон хэт их ашиглалтыг бууруулах, усны чанар, нөхөн сэргэлт, хүртээмжийг хангах; түүнчлэн хөрс хамгаалал, уурхайн талбайн нөхөн сэргээлт, нутгийн ургамал, амьтны аймгийг танин мэдэх, хадгалах, хамгаалах замаар биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээг өөрсдийн боломж чадавхын хүрээнд хэрэгжүүлнэ.

3-р ҮЕ ШАТ: Уул уурхайн үйлдвэрлэгчид нь SBG-ийн 27 шалгуур үзүүлэлтийг хангасны дараа тогтвортой гүйцэтгэлийг хангах, түүнчлэн SBG Холбооноос шаарддаг тухайн үйл ажиллагааны түвшний тасралтгүй сайжруулалтын төлөвлөгөөнд уялдуулахын тулд үйл ажиллагааны практик, тогтолцоог үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ёстой. SBG-ийн хэрэгжүүлэгч түншүүд нь үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг SBG-ийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тасралтгүй хяналт тавьж**,** SBG-ийн баталгаажуулалтын удирдамжид заасны дагуу SBG Холбоонд тогтмол тайлагнадаг.

5. ХЯНАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ

SBG-ийн найдвартай болон нэгдмэл байдал нь хоёр үндсэн тулгуурт суурилдаг. Нэгдүгээрт, SBG-ийн хэрэгжүүлэгч түншүүдийн уурхайн үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаанд явуулдаг байнгын хяналт, шинжилгээ. Хяналт шинжилгээ нь үйлдвэрлэгчийг анх тодорхойлохоос (эхний үнэлгээ) эхлэн, үйлдвэрлэгч SBG-ийн хөтөлбөрт хамрагдахаар шийдвэрлэснээс хойш тасралтгүй үргэлжилнэ. Үүнд: хэрэгжүүлэгч түнш нь зөрүүний шинжилгээ хийх, техникийн туслалцаа үзүүлэх, тасралтгүй сайжруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, өмнөх үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг газар дээр нь шалгах, томилолтын үр дүнг тайлагнах, SBG-ийн шаталсан аргачлалын (Эскалатор) дагуу үйлдвэрлэгчийн гаргасан ахиц дэвшилд зөвлөмж өгөх[16] зэргээр үйлдвэрлэгчтэй байнгын холбоотой хамтран ажиллана.

Хоёрдугаарт, хэрэгжүүлэгч түнш байгууллага нь уул уурхайн үйлдвэрлэгчид 2-р үе шатанд орохыг зөвлөж, улмаар SBG Холбооноос тухайн үйлдвэрлэгчийг SBG-ийн нийлүүлэгч гэж магадлан итгэмжилнэ.

15 2021 оны 9-р сараас хэрэгжиж эхэлсэн.
16 Хяналт шинжилгээнд талбай дээрх гэрээлэгчид мөн хамрагдана.

Энэхүү баримт бичиг нь Швейцарын Хариуцлагатай алтны холбооны (Swiss Better Gold Association-SBG) өмч бөгөөд эрх эзэмшигчээс бичгээр тусгайлан зөвшөөрөл олгоогүй тохиолдолд аливаа хэлбэрээр хуулбарлах, задруулах, ашиглахыг хориглоно.
© Swiss Better Gold 2025
Дэлгэрэнгүй мэдээллийг: info@sbga.ch

Үйлдвэрлэгч хөтөлбөрт үргэлжлүүлэн хамрагдах шаардлага хангаж буй эсэхийг дахин баталгаажуулах зорилгоор магадлан итгэмжлэл авснаас хойш хоёр жилийн дотор гуравдагч этгээдийн баталгаажуулалтыг заавал хийлгэнэ. Баталгаажуулалтыг хоёр (2) жил тутамд давтан хийнэ.

Гуравдагч этгээдийн баталгаажуулалт нь үнэлгээ хийгдэж буй байгууллагаас хараат бус байдаг тул илүү өндөр итгэл үнэмшилтэй гэж үздэг. Гэсэн хэдий ч, ялангуяа бичил уурхайн салбарт стандартын тогтолцоогоор баталгаажсан аудиторуудын үйлчилгээний зардал нь ихэвчлэн маш өндөр байдаг. Иймээс SBG Холбоо нь зах зээлд хүлээн зөвшөөрөгдөх түвшний баталгаажуулалтыг хангахын тулд үян хатан арга барил шаардлагатай гэж үздэг.

SBG-ийн эх үүсвэрийн хөтөлбөр нь жижиг алт олборлогчдод хэт өндөр зардал үүсгэхгүйгээр зах зээлийн шаардлага, хүлээлтийг хангах зорилгоор дараах хяналт, баталгаажуулалтыг хэрэгжүүлдэг.

- 1-р шатны баталгаажуулалтыг хийхдээ SBG Холбоо нь уул уурхайн үйлдвэрлэгчдийг сонгох, хяналт, шинжилгээний үйл ажиллагаанд SBG-ийн хэрэгжүүлэгч түншүүд, мөн гишүүдийн сонгон ажиллахаар шийдсэн, мэргэшсэн гэж өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн бусад гуравдагч талуудтай хамтран ажилладаг.
- 2-р шатанд хийгдэх магадлан итгэмжлэлийн хувьд, магадлан итгэмжлэл олгодог SBG Холбоонд хэрэгжүүлэгч түнш зөвлөмж өгдөг. Түүнчлэн үйлдвэрлэгчид 2-р шатны магадлан итгэмжлэл авснаас хойш 24 сарын дотор эх үүсвэрийн шалгуурыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор SBG Холбоо нь батлагдсан, мэргэшсэн, хараат бус гуравдагч этгээдүүдтэй[17] гэрээ байгуулдаг. Баталгаажуулалтын байгууллага эсвэл үнэлгээчдийн үйл ажиллагаа нь ISO17001:2005 эсвэл түүнтэй дүйцэхүйц хүлээн зөвшөөрөгдсөн нийцлийн удирдамж, стандартын зарчмуудтай нийцсэн байх[18] бөгөөд ISAE3000 эсвэл ISO19011:2011 зэрэг менежментийн тогтолцооны аудитын стандартуудтай танилцсан байх шаардлагатай. SBG Холбоо нь үйлдвэрлэгчдийг дахин баталгаажуулахдаа чанарын тогтмол байдлыг хангахын тулд мэргэшсэн хувь хүмүүс болон баталгаажуулалтын байгууллагуудын бүртгэл гаргаж болно.
- 3-р шатанд, SBG Холбоо нь үйлдвэрлэгчдийн гүйцэтгэлийг үргэлжлүүлэн хянах, тайлагнах ажилд SBG-ийн хэрэгжүүлэгч түншүүд, мөн гишүүдийн сонгон ажиллахаар шийдсэн, мэргэшсэн гэж өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн бусад гуравдагч талуудтай хамтран ажилладаг.

6. ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭГДЭЛ

SBG-ийн эх үүсвэрийн стратегийн зайлшгүй бөгөөд чухал нэг бүрэлдэхүүн хэсэг нь

[17] SBG Холбоо нь мэргэшсэн хараат бус гуравдагч этгээдээр батлуулахын тулд хангасан байх шаардлагатай шалгуурыг тогтоодог. Түүнчлэн Холбоо нь шаардлагатай тайлагналын загварыг тодорхойлдог.

[18] Баталгаажуулалт, нотолгоожуулалтын үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг сонгох зарчимд шударга байдал, чадамж, шийдвэр гаргалтад баримтад суурилсан хандлагатай байх, нээлттэй байдал, мэдээллийн нууцлалыг хадгалах, хариуцлага, баталгаажуулалтын түвшин болон хариуцлага хүлээх чадвар зэрэг багтана.

Энэхүү баримт бичиг нь Швейцарын Хариуцлагатай алтны холбооны (Swiss Better Gold Association-SBG) өмч бөгөөд эрх эзэмшигчээс бичгээр тусгайлан зөвшөөрөл олгоогүй тохиолдолд аливаа хэлбэрээр хуулбарлах, задруулах, ашиглахыг хориглоно.
© Swiss Better Gold 2025
Дэлгэрэнгүй мэдээллийг: info@sbga.ch

хөтөлбөрт оролцож буй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйлдвэрлэж, боловсруулсан хэмээн борлуулж, сурталчилж буй алттай холбоотой мэдэгдлүүдийг (мөн төөрөгдүүлж болзошгүй мэдэгдлүүд) зохицуулах явдал юм. SBG Холбоо нь энэ талаар мэдэгдэл хийх удирдамж боловсруулсан бөгөөд цахим хуудаснаас (https://swissbettergold.ch/about-us) үзэх боломжтой.

7. ҮЛ НИЙЦЭЛ

SBG-ийн үйлдвэрлэгч нь SBG-ийн зарчмуудыг (Эх үүсвэрийн стратеги, баталгаажуулалтын удирдамж, SBG Сангийн бодлого, Мэдэгдэл хийх удирдамж болон бусад баримт бичигт тусгасан) ноцтой зөрчсөнийг “Үл нийцэл” гэнэ. Үүнд олон улсын стандарт, магадлан шинжилгээний протоколыг зөрчсөн, эсвэл хүний эрхийн зөрчил, бусад нийгэм, байгаль орчны сөрөг нөлөөлөлтэй холбоотой ноцтой хямрал бий болсон зэрэг тохиолдлууд орно. Зөрчлийн ноцтой байдлын зэргийг тухайн нөхцөл байдал, болсон үйл явдал болон үүссэн эрсдэлд үндэслэн SBG Холбооны Удирдах зөвлөл тогтооно.

Дараах тохиолдлууд нь SBG-ийн зарчмуудад үл нийцнэ. Үүнд:

- SBG-ийн эх үүсвэрийн шалгуурт нийцэхгүй байх
- SBG Сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй техникийн туслалцаа, нийгэм, байгаль орчны төслүүдийг үндэслэлгүйгээр хэрэгжүүлэхгүй байх
- SBG-ийн мэдэгдэл хийх удирдамжийг зөрчсөний улмаас SBG-ийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх, эсвэл бусад сөрөг үр дагавар үүсгэх
- SBG Холбоо нь байгууллагын нэр хүндэд эрсдэл учирсан гэж үзэх
- SBG Холбооны Дүрэмд, ялангуяа 3 дугаар зүйлд (https://swissbettergold.ch/about-us) тусгасан үнэт зүйлсээс ноцтойгоор зөрөх

SBG Холбоо нь үл нийцлийн тохиолдлуудыг шинжилдэг. Шаардлагатай гэж үзвэл Холбоо нь тухайн хамтрагч байгууллага, үйлдвэрлэгчээс илэрсэн асуудлыг арилгах сайжруулалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхийг шаардана. Хэрэв сайжруулалтын төлөвлөгөөг 6 (зургаан) сарын дотор хэрэгжүүлж эхлүүлээгүй бол Холбооны зүгээс түдгэлзүүлэх, мөн ямар нэгэн ахиц, сайжруулалт огт хийгдээгүй гэж үзэн SBG хөтөлбөрөөс бүрмөсөн хасах асуудлыг авч хэлэлцэнэ.

Үл нийцлийг дараах сувгаар мэдээлж болно. Үүнд:

- SBG-ийн гомдол, санал хүлээн авах механизмаар
- SBG-ийн хэрэгжүүлэгч түншүүдээр дамжуулан
- SBG-ийн баталгаажуулагчдаар дамжуулан
- SBG-ийн үйлдвэрлэгч өөрөө мэдээлэх замаар

Энэхүү баримт бичиг нь Швейцарын Хариуцлагатай алтны холбооны (Swiss Better Gold Association-SBG) өмч бөгөөд эрх эзэмшигчээс бичгээр тусгайлан зөвшөөрөл олгоогүй тохиолдолд аливаа хэлбэрээр хуулбарлах, задруулах, ашиглахыг хориглоно.
© Swiss Better Gold 2025
Дэлгэрэнгүй мэдээллийг: info@sbga.ch